



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 11 өдөр

Дугаар А/282

Чингис хот

Цэцэрлэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын "а", Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Боловсрол, соёл, урлагийн газрын санал, дүгнэлтийг үндэслэн Хэрлэн сумын IX цэцэрлэгийг байгуулсугай.

2. Хэрлэн сумын IX цэцэрлэгийн сургалт хүмүүжлийн ажлыг холбогдох хууль, журмын дагуу мэргэжил, арга зүйн зөвлөгөө, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Боловсрол, соёл, урлагийн газар /С.Мөнхцэцэг/-т, дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллахыг Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын захирагч /Ц.Идэрбат/ нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА